

БҮГД НАЙРАМДАХ УКРАИН УЛСЫН ТЭТГЭЛГИЙН ТУХАЙ

Жил бүр Монгол Улсаас Бүгд Найрамдах Украин Улсад тодорхой тооны Монгол иргэдийг хяналтын тоонд багтаан сонгон шалгаруулж бакалаврын хөтөлбөрт суралцуулдаг. Жил бүр элсүүлэн суралцуулах оюутны тоо янз бүр байж болно.

Бакалаврын хөтөлбөр хугацаа: Жил бүрийн I-II сард

Жил бүр дутагдалтай байгаа ажлын байрны хэрэгцээ шаардлагатай уялдуулан суралцах чиглэлийг өөрчилж зарладаг.

Суралцах мэргэжлийн зарим үндсэн чиглэл:

- Нисэхийн инженер
- Авто замын инженер
- Төмөр замын инженер
- Авто тээвэр зохион байгуулалт
- Анагаах ухаан

Тэтгэлгийн хамран суралцах хугацаа: 4 жилийн хугацаатай сургалт

Тавигдах шаардлага:

1. Өргөдөл гаргагч нь 21 нас хүртэлх Монгол Улсын иргэн байх.
2. Бүрэн дунд боловсролын гэрчилгээний дундаж үнэлгээний голч дүн 80-иас дээш, их дээд сургуулийн I-II курст суралцдаг бол голч дүн 3,0 ба түүнээс дээш байх шаардлагатай
3. Өмнө нь аль нэг улсын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаагүй байх.
4. Орос хэлний бэлтгэл бүрэн хангасан байх, эсвэл Монгол Улсын орос хэлний гүнзгийрүүлсэн сургалттай болон ОХУ-тай хамтарсан ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангид 80 ба түүнээс дээш хувийн амжилттай суралцаж байгаа.

Сонгон шалгаруулалтын үйл явц:

Цахим өргөдөл (www.esis.edu.mn /grant холбоосоор хандаж цахим өргөдөл бөглөн, баримт бичгийг өргөдөлд татаж оруулна)

Бакалаврын сонгон шалгаруулалтыг бичгийн шалгалт болон ярилцлага гэсэн үе шаттай зохион байгуулна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийг тухайн орны Засгийн газрын тэтгэлгээр суралцуулахаар нэр дэвшүүлнэ.

Хүлээн авах тал тухайн нэр дэвшигчийг суралцуулах тухай эцсийн шийдвэрийг гаргана. Засгийн газрын тэтгэлэгт сургалтын төлбөр ба амьжиргааны тэтгэлэг багтана. Бусад зардал (замын зардал, эрүүл мэндийн даатгал гэх мэт)-ыг суралцагч өөрөө хариуцна.

Дэлгэрэнгүй мэдээллийг: БСШУСЯ-ний www.mecs.gov.mn сайтын гадаадад суралцах хэсгээс авна уу.